



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө
бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 408 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монсам” ХХК-иас Бүгд Найрамдах Солонгос улсын Экспорт-Импорт банкинд төлөх өрөнд тооцон шилжүүлсэн 198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандан “Монсам” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хүчингүй болгож, Сангийн яамны нэр дээр шилжүүлэн бүртгүүлэх;

2.2 Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ



000119

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 04 дүгээр сарын 21-ны
өдрийн 142 дугаар тогтоолын хавсралт



САНГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	хэмжих нэгж	тоо ширхэг	Нийт үнэ (төгрөг)
1	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, 18 дугаар байрны 11 тоот (өргөтгөл хийсэн орон сууцны байр)	1995	ш	1	198,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)	198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая)